

Үдээс өмнөх хуралдааны хэлэлцүүлэг

Хэлэлцүүлгийн чиглүүлэгч: Р. ТӨРДАЛАЙ
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)

Доктор Р.Төрдалай: "Олон улс судлал-2022: Монголын Япон судлал" эрдэм шинжилгээний хурлын үдээс өмнөх илтгэлүүд маань хөтөлбөрийн дагуу цагтаа явагдаж дууслаа. Үдийн зоогоос өмнө та бүхэнтэйгээ үдээс өмнөх хуралдааны хэлэлцүүлгийг өрнүүлбэ. Та бүхэнд сонирхсон асуулт, санал байвал чөлөөтэй асууж ярилцана уу.

Доктор Д.Уламбаяр: Олон сайхан сонирхолтой илтгэлүүд сонслоо. Үдээс хойш сургууль дээр хичээлтэй учраас үдээс хойших илтгэлийн хэлэлцүүлэгт сууж амжихгүй тул хүлцэл өчөөд үдээс өмнөх илтгэлүүдийн талаар товчхон саналаа хэлбэ.

Эхний илтгэл болох У.Загдцэсэмийн илтгэл сонирхолтой байлаа. Дорно дахины хүрээлэн байхаас Олон улс судлалын хүрээлэн хүртэл Япон судлал өдийг хүртэл тасралтгүй хөгжиж судалгааны цар хүрээгээ тэлсэн байна. Үүн дээр нэмж хэлэхэд 1974 онд "Маоизм ба Маогийнхан" гээд том хэмжээний 300-аад хуудас ном гарч байсан. Японы талаар гүнзгий сайн судалгаатай ном гарч байсан. 2002 онд гурав дахь хөрш биш гурав дахь түнш гэдэг нэрээр ШУТС-гийн хамтарсан төсөл буюу ном гарч байсан. Үүнд бас хамтран зохиогчоор оролцсон. Энэ бүтээлд Японыг түнш орон гэдгийг тухайн үед хөндөж байсан байдаг.

С.Баттулга багшийн илтгэл сонирхолтой байлаа. Сүүлийн үед "Resilience" гэх нэр томъёо олон улсын байгууллагуудын баримт бичигт түрэн орж ирсэн. Тэсвэртэй эдийн засгийг цогцлоох гэдэг дээр их сонсогдох боллоо. Судалгаанаас харахад "Resilience"-ийг өргөн утгаар сонирхолтойгоор үечилсэн байдаг юм билээ. 1-р үе шат нь тэсэж үлдэх, 2-р үе шат нь даван туулах, 3-р үе шат нь дасан зохицох 4-р үе шат нь хариу барих, 5-р үе шат нь хүнд нөхцөл байдлаас нэр хүндтэй даван гарах. Энэ олон асуудал дээр яригдах байх, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт гээд мөн олон сэдэв байна. С.Баттулга багш илтгэлдээ "Ковид-19"-ийн жишээн дээр асуудлыг хөндөж ярилаа. Энэ бол маш сонирхолтой байлаа. Энэхүү хуралд оролцож байгаа ганц япон илтгэгч Мүрай багшийн маань илтгэл их сонирхолтой байлаа.

“Говь” ноолуурын үйлдвэрийн түүхэн замналыг тодорхой баримттай ярилаа. Мөн М.Золзаяа илтгэгчийн Японы философийн талаарх илтгэл сонирхолтой байлаа. Японы хөөн гүйцэх, гүйцэж түрүүлэх философи, Канаме Акамацүгийн гол чиг баримтлал бол ерөөсөө эдийн засгийн философи юм гэдэг санааг илэрхийлэх гэсэн юм. Наранбаяр илтгэгчийн Мэйжигийн үеийн шинэчлэл гээд олон сонирхолтой илтгэл сонслоо. Үр дүнтэй сайхан хурал болж байна гэж үзэж байна. Их баярлалаа.

Магистр М.Хишигтуяа: М.Золзаяа доктороос асуулт асууя. Монголд Японы шашны байгууллага хэр их байдаг вэ?

Доктор М.Золзаяа: Манай хүрээлэнгээс гаргасан Монгол Улс дахь шинэ шашнууд: нийгмийн төрх, асуудал, шийдэл гэдэг бүтээлийн хавсралтаас шинэ төрлийн шашны урсгалуудыг харж болно. Японы шашны байгууллагууд жагсаалтад нь байгаа. Энэхүү жагсаалтад бол голлох 10 гаруй байгууллагууд байгаа. Тэндээс харж болно.

Доктор Р.Төрдалай: С.Баттулга багшаас асуулт асууя. Дэлхий дахин нүүр тулсан “Ковид-19” цар тахлын үеийг даван туулсан Японы “Resilience”-ийн тухай ярилаа. Энэ хүрээнд Таны илтгэл хэвлэл мэдээллийн талаарх асуудал дурдагдлаа. Японы хэвлэл мэдээлэл “Ковид-19” цар тахлын үед ямар горимоор ажилласан бэ? Энэ талаар тодруулж өгнө үү.

Доктор С. Баттулга: “Японы Засгийн газраас баримталж буй бодлого нь вирусийг дарах, улс орны нийгэм, эдийн засгийн хохирлыг багасгах тал дээр чиглэж, эрдэмтдийн санал, дээрээс нь судалгаан дээр тулгуурлаж, Засгийн газраас шийдвэр гаргаж, олон нийтийг хурдан шуурхай, хүртээмжтэй, мэдээллээр хангахад онцгой анхаарч ажилласан нь эхний үе шатанд кластерийн хяналтын аргыг амжилттай хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэхийн тулд харьцангуй эрт арга хэмжээ авсан. Ковидын үед Японы улс төрийн томоохон үйл явдлууд ч өрнөсөн. Монголд ч мөн ялгаагүй.

Доктор С.Туул: Япон улс аливаа эрсдэлд бэлтгэлтэй байдаг. Газар хөдлөлт байнга болдог учраас бэлтгэлтэй байдаг. Бүх зүйл тодорхой байдаг. Манайхан шиг гэнэт сандрах биш. Засгийн газрын хувьд шуурхай ажиллаж байсан. Хувь хүмүүс таны хэлснээр их хувь нэмэр оруулсан. Засгийн газар чадах бүхнээ хийж бүгдийн хүчээр эрсдэл багатай. давсан. Зоогийн газар, паб, ресторан гээд олон нийтийн газрыг эхний үед хааж байсан боловч хувийн хэвшил дампууралд орж байсан болохоор шат дараатай ковидын үеийн хориг арга хэмжээнүүдийг

бага багаар сулруулж байсан. Эхлээд 5 цагт, 6 цагт, 7 цагт хүртэл ажиллуулаад хаах жишээтэй. Хилийн хориг тэдний хэмжээнд маш чанга байсан. Бас мөнгөн тусламж, 100 мянган иен өгч байсан, ард иргэдийн сэтгэлийг засаж байсан. Зөвхөн япон иргэн гэлтгүй байнгын оршин суугаа гадаадын иргэнд ч гэсэн тусламж үзүүлж байсан.

Доктор С.Баттулга: Мүрай багшаас асуулт асууя. Засгийн газрын бодлогын талаар хэр зэрэг шүүмжлэлтэй байгаа вэ?

Доктор Мүрай: Нэг их шүүмжлэл байхгүй. Японы Засгийн газар, Монголын Засгийн газрын авч байгаа арга хэмжээ төстэй байсан.

Доктор С.Баттулга: Сүүлийн үед Монголд өрнөж байгаа хөдөлгөөн бол ковидын дараах үеийн эсэргүүцэл гэж би ойлгож байна. Ковидын үеийн 2-3 жилийн стресс бухимдал шүү дээ. Японы нэг зүйлийг онцолмоор байна. Тогтворгүй байдлыг үүсгэхгүй байх арга хэмжээг анхнаасаа бодож төлөвлөдөг. Энэ чинь "Resilience" шүү дээ. Нэгэнт ийм том эрсдэлтэй нүүр тулахад ард түмэн яаж хандах ёстой вэ, Засгийн газраас юу шаардах ёстой вэ гэдэг Монголтой бол харьцуулшгүй. Тэд бол өндөр боловсролтой. Бид нар тэр хэмжээнд хүрээгүй байгаа. Бид нар харин суралцах ёстой юм. Түүнээс биш бид нар Японы философийг авах бодлогыг ярих шаардлага байхгүй. Эсрэгээрээ ийм нийгэмд өрнөж байгаа зүйлийг философичид ярих ёстой. Энэ талаар яригдахгүй байгаад би гайхдаг. Дуугарах ёстой. Философичид л ярихгүй бол энгийн хүн ярихгүй шүү дээ.

Доктор С.Туул: Би бас санал нийлж байна. Би Болгар улсад боловсрол судлалаар доктор хамгаалах болсон. Их сургуульд сурсан сэтгэл судлалын хичээл стандарт шаардлага хангахгүй, доктор хамгаалах хугацаандаа дахиж судал гэж байсан. Психологи гэдэг чинь том шинжлэх ухаан. Ялангуяа англи хэл заахдаа хүүхдийн сэтгэл зүйг ойлгох хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосон. Япон хүний хувь хүний ухамсрын өндөр түвшинд байдаг. Биднийг хүчээр хорьж, цагдаж байхад бид бол бухимдаж байсан. Мүрай багштай утсаар ярихад манай тосгоны дарга биднээс шаардаагүй, гуйсан. Та 7 хоногт 2 удаа л дэлгүүр явах эрхтэй. 2 удаа явахдаа 7 хоногийнхоо хүнсийг цуглуулах ёстой шүү гэж. Ёс зүйтэй сахилга баттай учраас энэ эрсдлийг сайхан давсан болов уу гэж байна. Эрсдэл багатай манайхаас бухимдал багатай давсан болов уу гэж бодож байна. Засгийн газар тухай үед сайн ажилласан. Хоолгүй болсон иргэдэд хоол хүнсээр хангах жишээтэй. Иргэдийн бухимдлыг арилгах үүднээс шат дараатай бага багаар өгөөд хүмүүсийн сэтгэл зүйг эмчилчихлээ гэж харж байна.

Доктор М.Золзаяа: Нийгмийн боловсролын түвшинтэй холбоотой юм хүчийг авдаггүй. Жишээ нь ерөнхий боловсролын сургуульд дээрэлхэлтийн асуудлаар лекц уншуулъя гэж бодсон чинь эрдэмтэн хүн очоод унших уу, дуучин Гантогоогоор уншуулах уу гэдэг дээр судалгаа гаргаж ирээд Гантогоогоор уншуулж байсан. Тиймээс манай нийгмийн сонсох түвшин доогуур байна уу гэж боддог.

Үдээс хойших хуралдааны хэлэлцүүлэг

Хэлэлцүүлгийн чиглүүлэгч: Д.ЗОЛБОО
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал,
доктор (Ph.D), дэд профессор

Доктор Д.Золбоо: Үдээс хойших хуралдаанд хөтөлбөрийн дагуу цагаа баримтлан илтгэлээ хэлэлцүүлж буй илтгэгч нартаа баярлалаа. Үдээс хойших хуралдааны хэлэлцүүлэг цагтаа эхэлж байна. Илтгэлүүдтэй холбогдуулан сонирхсон асуултаа асуух хүн гараа өргөөд асуугаарай.

Докторант Л.Бямбаханд: Сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн илтгэгч нартаа баярлалаа. Дэд хурандаа Хишигсүрэнгээс асуулт асууя. Монгол-Японы батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны сэдвийн хүрээн дэх баримт бичгүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Монгол Улс энхийг сахиулах үйл ажиллагаанд цэргээ явуулахаар нэлээд цэргээ татаж байгаа. “Хааны эрэлд” бол Америк, Монголын харилцаанд чухал үүрэгтэй цэргийн сургууль байдаг. Эсрэгээрээ Японы хувьд өөрийгөө хамгаалах цэргийн хүчин нь Үндсэн хуулийн 9 дүгээр заалтаас болоод батлан хамгаалах хүчин чадлаа илүү их хязгаарласан бодлогуудыг явуулж ирсэн. Энэ утгаараа энхийг сахиулах үйл ажиллагаа учир дутагдалтай байдаг уу? Манайхаас суралцах зүйл Японд ер нь байдаг уу? Монголчууд зам барих тал дээр Японоос суралцаж байгаачлан энхийг сахиулах үйл ажиллагаанд цэргийн сургуулилтад туршлагаа хуваалцах боломж байдаг уу? Та бас маш олон сургалтад хамрагдаж байсан юм байна. Миний бодлоор Монгол Улсын хувьд цэргийн боловсон хүчин нь илүү их ЗХУ-д бэлтгэгдсэн байдаг. Харин Японы хувьд давуу тал нь юу вэ? Цэргийн номлол байлдааны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг вэ?

Дэд хурандаа Х.Хишигсүрэн: Энхийг сахиулах ажиллагааны “Хааны эрэлд” олон улсын сургалт дадлагыг АНУ-тай хамтран зохион байгуулдаг.

Энэ сургалтын зорилго нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох цэргийн албан хаагчдаа сурган дадлагажуулах, цаашлаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилготой. Монгол Улс 2002 оноос энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсэн. Энэ жил 20 жилийн ойгоо тэмдэглэсэн. Япончуудын тухайд мөн адил энхийг сахиулах ажиллагаанд оролцдог. Гэхдээ таны хэлсэнчлэн хязгаарлалт ихтэй, оролцож байгаа хүний тоо цөөхөн, оролцох боломжит хүрээ нь нэлээд хумигдсан байдалтай оролцдог. Монгол Улсын зэвсэгт хүчний албан хаагчид болон Японы алба хаагчид Иракийн сэргээн босголтын арга хэмжээнд аль аль нь оролцож байсан туршлагатай учраас ер нь гарааны хувьд тун ойролцоо. Аль аль талаасаа суралцах боломжтой. Мэдээж, Япон Улсын хувьд өндөр хөгжилтэй улс, техник технологийн хөгжил, хүн ам ихтэй учраас ойролцоогоор 250 мянга гаруй алба хаагчидтай. Тийм учраас аль аль талаасаа суралцах боломжтой.

Бидний Америктай хамтран зохион байгуулж байгаа “Хааны эрэлд” сургалтад Японы талаас жил бүр сургагч багш нар ирдэг. Урьдчилаад сургагч багшийн дамжаанд суугаад сурч мэдэж дадлагажсаны дараа “Хааны эрэлд” сургалтад багшилдаг. Ганц Япон биш бусад улсууд ч мөн адилхан. Манай цэргийн албан хаагчид мөн багшлах хэмжээнд бэлтгэгдээд бусдад сургаад явж байна. Мэдээж манай улсын давуу талыг ярих ёстой байх. Монгол Улсын тухайд энхийг сахиулах ажиллагааны чиглэл зэвсэгт хүчний нэг гол үүрэг болсон. Манай цэргийн албан хаагчид Япон болоод бусад улсын цэргийн албан хаагчдад зааж сургах бүрэн боломжтой.

Миний ажиллаж байгаа зэвсэгт хүчний 311 дүгээр анги буюу Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төв гэдэг байгууллага нь дотроо олон төвтэй. Нэг төв нь энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв байгаа. Энэ сургалтын төв нь өөрөө бие даагаад НҮБ-ын асар олон сургалтуудыг зохион байгуулдаг. Хамгийн сүүлд энэ онд НҮБ-ын Штабын офицерын дамжааг бие даан зохион байгуулах бүрэн боломжтой гэсэн сертификатыг НҮБ-аас албан ёсоор олгосон. Хойшид ажиглагч офицерын болон цэргийн багийн захирагчийн олон сертификатуудыг авах байх. Тэгэхээр бидний хувьд сурган дадлагажуулах дадлага чадварын тухайд энхийг сахиулах ажиллагаанд миний хувь бодлоор Японоос давуу талтай.

Гэхдээ Японыг талыг ойлгох хэрэгтэй. Япон олон хязгаарлалттай, ард түмний хандлага, өөрийгөө хамгаалах хүчиндээ хандах хандлага хүнд хэцүү учраас боломж тун хомс, Үндсэн хуулийн заалтаас шалтгаалаад адаглаад буу зэвсгээ зөөж тээвэрлэхэд хүндрэлтэй тал байдаг. Таны

хэлсэнчлэн Монгол Улсын зэвсэгт хүчний алба хаагчид хуучнаар ЗХУ-д асар олон хүн сурган бэлтгэгдэж ирсэн. Ардчилал хөгжөөд 1990-ээд оны эхнээс дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай хөл нийлүүлье, цэргийн шинжлэх ухааны хөгжил дэвшил ололттой талуудыг эзэмшье, цаашлаад ганц цэргийн гэлтгүй өндөр хөгжилтэй оронд боловсрол эзэмшиж, Монгол Улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулъя гэдэг үүднээс олон оронд боловсрол эзэмшиж байгаа. Ганц Япон биш Америк, Солонгос, Герман, Англи, Канад гээд маш олон улс бий. Японы тухайд гэвэл 1998 оноос суралцаж эхэлсэн. Мэдээж давуу тал байдаг. Манай удирдлагын бүрэлдэхүүний хандлага Японд төгссөн офицеруудыг удирдлагад ажиллуулах сонирхолтой байдаг. Яагаад гэвэл япончуудын ажилч, хичээнгүй, зарчимч чанарыг шингээгээд ирсэн байдаг болов уу.

Доктор М.Эрдэнэбаяр: Доржсүрэн доктороос асуулт асууя. Японы аюулгүй байдлын бодлогууд нэлээд өөрчлөгдлөө. Олон улсын нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан энэ цаг үед Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа өөрчлөх тал дээр таны бодол ямар байна вэ? Манай улсад өөрчлөх шаардлага үүссэн үү? Мөн гуравдагч хөршийн бодлого бас өөрчлөгдөх болов уу? Энэ том баримт бичиг нь богино хугацаанд өөрчлөгдөх нь хэр эрсдэлтэй байдаг вэ?

Доктор Н.Доржсүрэн: Асуулт асуусанд баярлалаа. Миний хувьд шийдвэр гаргах түвшний хүн биш болохоор тодорхой хариулт өгмөөргүй байна. Яагаад энэ сэдвийг сонгосон бэ гэхээр Японы хувьд аюулгүй байдлын орчин өөрчлөгдөж байна. Яг энэ нөхцөлд Монгол Улс яах вэ гэдэг дээр хариулт өгөхөөс илүү үүнийг судлах ёстой гэдэг үүднээс сонгосон. Японы хувьд батлан хамгаалах бодлогоо өөрчлөх шалтгаан гадаад хүчин зүйлээс илүү Үндсэн хуулийн өөрчлөлтөөс авхуулаад дотоод хүчин зүйл нөлөөлсөн болов уу. Энэ талаар олон нийтийн санал асуулга явсан, 60-аад хувь нь батлан хамгаалах хүчнээ бүрдүүлнэ, өөрчлөх хэрэгтэй гэсэн саналтай байсан. Орос, Хятад хоёр хөрш маань Японы хувьд сорилт болоод байгаа энэ нөхцөлд бид нар яаж хандах ёстой вэ гэдэг асуулт гаргаж тусгай хэлэлцүүлэг өрнүүлэх ёстой болов уу гэж бодож байна.

Доктор С.Баттулга: Доржсүрэн доктороос асуулт асууя. Япон бол Америктай түншлэлтэй явж ирсэн, батлан хамгаалахын салбарт хамтарч оролцдог, тодорхой үүрэг хүлээдэг улс. Эртнээс бага багаар батлан хамгаалахаа бэхжүүлье гэсэн бодолтой явсан. Ерөнхий сайд Шинзо Абэ ч бас ийм бодолтой явсан. Гэхдээ Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж чадсангүй. Орос-Украины мөргөлдөөн маш их түлхэц өглөө гэж бодож байна. Батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлэх далим

боллоо гэж бодож байна. Батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлэх тал дээр хэлэлцүүлэг их өрнөж байна. Хэлэлцүүлэг маш задгай явагддаг. Олон нийтийн дунд өрнөж байгаа хэлэлцүүлгийг шууд ийм тийм гэж дүгнэхэд учир дутагдалтай байх. Ийм учраас олон улсын нөхцөл байдал нөлөө үзүүлж байна гэж үзэж байна. Украины нөхцөл байдлаас болоод Японы Либерал Ардчилсан Намд Хятадтай харилцах харилцаа нь гүнзгий фракцууд байдаг. Энэ харилцаанд хэр өөрчлөлт гарсан бэ? Тэр тал дээр юу ажиглагдаж байна вэ?

Доктор Н.Доржсүрэн: Украины асуудал бол таны хэлснээр нэлээд том түлхэц болсон. Украины асуудалд анхнаасаа Япон бол Оросын эсрэг байсан. Оросын эсрэг эрчим хүчний хориг арга хэмжээ, мөн Сахалин-2, 1 төслөөс болоод өөрийнхөө улс орны эрх ашгийн үүднээс Оростой хэрхэн харьцах вэ гэдэг дээр бие даасан бодлого явуулж байна гэж харж байна. Японы Либерал ардчилсан намын дотор Хятадтай ойр харилцаж байгаа фракцын талаар судлаагүй юм байна. Тайванийн асуудал Японы Либерал Ардчилсан Нам гэлтгүй Японы улс төрийн нөхцөл байдалд том сорилт болж байгаа учраас батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлэх хүчин зүйл болж байгаа байх.

Доктор С.Баттулга: Монгол-Япон тусгай стратегийн түншлэл гээд байгууллаа. Саяхан энэ талаар нэгэн арга хэмжээн дээр элчин сайдаас асуулаа. Тусгай стратегийн түншлэл гээд байгууллаа үүнийг та хэрхэн ойлгож байгаа вэ гэдгийг тоглоом маягаар асуусан. Бид нар үүнийг илүү их ойлгох шаардлагатай. Гуравдагч хөрш гэдэг утгаараа тусгай стратеги ярих гээд байна уу, тодорхой салбарт илүү хамтарч ажиллах гээд байна уу, эсвэл ойрын ирээдүйг харсан ямар нэгэн зүйл үү? Энэ талаар юу гэж бодож байна?

Доктор Н.Доржсүрэн: Энэ тал дээр тааж хэлмээргүй байна. Гэхдээ цаг хугацаа нь ингэж давхацсан юм болов уу гэж бодож байна. Япон Улсын Гадаад хэргийн сайд ирэхдээ олон улсын нөхцөл байдал ялангуяа Украины асуудал дээр нэг байр суурьтай байх болов уу гэдэг санаагаа шингээсэн юм болов уу гэж бодож байна.

Доктор С.Баттулга: Элчин сайд өөрөө бас хэлэхдээ “Орос, Хятад хоёртой Монгол Улс иж бүрэн стратегийн түншлэлтэй учраас бид адилхан нэртэй баймааргүй байна гэж” хошигнож хэлсэн юм. Доржсүрэн докторын хэлсэнчлэн цаана нь бас ийм санаа явж байж болох юм.

Доктор С.Баттулга: Хишигсүрэн дэд хурандаагаас асуулт асууя. Агаарын зэвсэгт хүчний хамтын ажиллагааны тухайд Япон улстай цаашид ямар чиглэлээр хамтарч ажиллах боломжтой вэ? Энэ талаар тодруулж өгнө үү.

Дэд хурандаа Х.Хишигсүрэн: Агаарын хамтын ажиллагаанд ямар чиглэлээр хамтарч ажиллах вэ гэхээр нэгдүгээрт, нисэх хүчнээ бэхжүүлэх. Хоёрдугаарт, Монгол Улсын зэвсэгт хүчин радио долгионы станц гэж байдаг. Энэ маань агаарын орон зайг хамгаалах хянаж байх үүрэгтэй. Гэтэл энэ маань хуучин ЗХУ-ын үеийн системүүд дийлэнх, хуучнаараа байгаа гэсэн үг. Үүнийг шинэчлэх, агаарын орон зайг бүрэн хамгаалж, хянах гэдэг үүднээс Японыг дэвшилтэт гэдэг утгаараа хамтарч ажиллах гээд байгаа болов уу гэж би ойлгож байна.

Доктор С.Баттулга: Хоёр хөрш болон Япон улс дижиталчлах стратеги гаргаад эхэлсэн. Дижиталчлах замаар бусад улсуудын мэдээллийг цуглуулах, хуримтлуулах тал дээр дэвшил гаргах зорилготой байгаа. Бусад улсуудын мэдээллийг нэвтрүүлэх нь хэр эрсдэлтэй вэ?

Дэд хурандаа Х.Хишигсүрэн: Энэ бол яах аргагүй агаарын цэргийн хамтын ажиллагаатай холбоотой. Бид бол хоёр хөрштэй. Хоёр хөрш маань том хөршүүд. Хоёр хөршийн хувьд цөмийн зэвсэгтэй, НҮБ-ын аюулгүй зөвлөлийн гишүүн, цэргийн болон эдийн засгийн чадавх гээд олон давуу талтай. Эдгээр улсуудыг давуулаад Япон болон Америктай харилцаагаа хөгжүүлэхэд туйлын хүндрэлтэй байдаг байх. Агаарын цэргийн хамтын ажиллагаа дээр яг Японтой хамтрахад асар их хүндрэл гарах байх. Нэгдүгээрт, хэнийг хянах вэ, хоёрдугаарт, яагаад Японтой хамтарч байна вэ, хянаад хянасан мэдээллээ яах вэ гэдэг асуудал яригдана. Тэр утгаараа хоёр хөрш маань дургүйцэх байх. Гэхдээ аливаа улсын зэвсэгт хүчний алба хаагчид тангараг өргөсөн эх орноо хамгаалах үүрэгтэй байдаг. Хоёр хөрш маань бидний хөгжил дэвшилд нэмэр болохгүй бол Японтой хамтарч ажиллаж, дижитал түвшний техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх нь зүйтэй юм. Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчнийхэн “Хааны эрэлд” сургалтад хамрагдахдаа эхний хоёр жилд Монгол Улсын зэвсэгт хүчинд ашиглаж байгаа зэвсгийг ашиглаж сургалтад оролцсон. Сүүлийн жилүүдэд өөрсдийн ашигладаг зэвсгээ авчирч ашиглаж оролцож байна. Хоёр, гурван жилийн хугацаанд хоёр хөршийн болно болохгүй саад хориг байсан учраас оруулж чадаагүй. Үүнийг даваад оруулж ирсэн нь гарц гаргалгаа хайж, зөв шийдэлд хүрсэн хэлбэр болов уу гэж бодож байна.

Доктор Р.Төрдалай: Энхжаргал багшаас асуулт асууя. Таны илтгэлд дурдагдсан. Сүүлийн 10 жилд судалгааны магистр, докторын чиглэлээр хамгаалсан хүмүүсийн тоо буурсан үзүүлэлттэй байна. Үүнд ямар шалтгаан, хүчин зүйл нөлөөлж байна вэ? МУИС дээр судалгааны магиструудын цагийн зохицуулалт ирэх жилд яаж өөрчлөгдөх вэ?

Доктор П.Энхжаргал: МУИС төдийгүй МУБИС, ШУТИС, ХИС-тай хамтарч ажилладаг учраас мэдээллүүдээс харахад ерөнхийдөө бүх салбарт нэгэн жигд багассан үзүүлэлттэй байна. Судалгааны магистр, мэргэжлийн магистрын хувьд сургалтын төлөвлөгөөний боловсруулалт надад байхгүй учраас сайн мэдэхгүй байна. Нэг их өөрчлөгдөхгүй болов уу. Ялангуяа судалгааны бус магистраар сурч байгаа чиглэлийг ерөнхийдөө харах юм бол орчуулагч мэргэжлээр төгссөн хүмүүс хэл шинжлэл чиглэлийг сонгоод явж байна. Хэл шинжлэлийн чиглэл нэлээн багассан нь Японд ахисан түвшинд суралцах боломж нээлттэй байгаа учраас орчуулагчаар төгссөн хүмүүс маань нэгэнт хэлтэй хүмүүс Японд суралцах хандлага илүү байгаатай холбоотой байгаа байх аа. Орон судлалын хувьд харьцангуй гайгүй.